

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2025/087/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2025.02.20	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576	Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a>
	Аудитын менежер Утас: 99061829	М.Алтантуяа Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a>
	Аудитор Утас: 88114307	Ц.Дорж Цахим хаяг: <a href="mailto:Dorjts@audit.gov.mn">Dorjts@audit.gov.mn</a>
	Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал .....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/41  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын тайлангаар илэрсэн алдаа, зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2024.11.18 -ны өдрийн 98 захирамжаар тус сургуулийн 150,019.4 мянган төгрөгийн балансын өртөгтэй сурагчдын 2 дугаар дотуур байрыг балансаас балансад шилжүүлсэн, Аймгийн Засаг даргын 2022.06.07 -ны өдрийн А/386 дугаар захирамжийн дагуу тус

**5020254**

сургуулийн эзэмшил 3 байршлын 38.185 м.кв газрын нэгжийн үнэлгээг дахин хийж 954,625.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгасан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллага энэ жил түүхт 100 жилийн ойн хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ





پہنچاؤ اور صحت ، پنجاب صحت و خاندان و نسلی امور

.. رجسٹرڈ ہونے کے لئے درخواستیں

میں داخلہ کیے جانے والے تمام افراد کو رجسٹرڈ ہونے کی ضرورت ہے۔ رجسٹرڈ ہونے کے بعد ہی وہ طبی سہولتوں سے فائدہ اٹھا سکیں گے۔

.. رجسٹرڈ ہونے کے لئے درخواستیں جمع کروانی ہیں۔ درخواستیں جمع کروانے کے بعد ہی وہ طبی سہولتوں سے فائدہ اٹھا سکیں گے۔

.. رجسٹرڈ ہونے کے لئے درخواستیں جمع کروانی ہیں۔ درخواستیں جمع کروانے کے بعد ہی وہ طبی سہولتوں سے فائدہ اٹھا سکیں گے۔

.. رجسٹرڈ ہونے کے لئے درخواستیں جمع کروانی ہیں۔ درخواستیں جمع کروانے کے بعد ہی وہ طبی سہولتوں سے فائدہ اٹھا سکیں گے۔

.. رجسٹرڈ ہونے کے لئے درخواستیں جمع کروانی ہیں۔ درخواستیں جمع کروانے کے بعد ہی وہ طبی سہولتوں سے فائدہ اٹھا سکیں گے۔

.. رجسٹرڈ ہونے کے لئے درخواستیں جمع کروانی ہیں۔ درخواستیں جمع کروانے کے بعد ہی وہ طبی سہولتوں سے فائدہ اٹھا سکیں گے۔

.. رجسٹرڈ ہونے کے لئے درخواستیں جمع کروانی ہیں۔ درخواستیں جمع کروانے کے بعد ہی وہ طبی سہولتوں سے فائدہ اٹھا سکیں گے۔

.. رجسٹرڈ ہونے کے لئے درخواستیں جمع کروانی ہیں۔ درخواستیں جمع کروانے کے بعد ہی وہ طبی سہولتوں سے فائدہ اٹھا سکیں گے۔

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>620,526,527.7</u></b>	<b><u>888,617,198.1</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	275,252,498.9	355,795,029.2
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	275,252,498.9	355,795,029.2
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	275,252,498.9	355,795,029.2
31211	Төрийн сангийн харилцах	275,252,498.9	355,795,029.2
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,105,500.0	1,636,219.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.0	1,636,219.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,000,000.0	00.0
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	105,500.0	00.0
3351	Байгууллагаас авах авлага	105,500.0	00.0
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	2,748.0	00.0
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	2,748.0	00.0
34713	Цалингийн урьдчилгаа	2,748.0	00.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	344,165,780.8	531,185,950.0
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,688,700.0	2,720,200.0
35130	Эм боох материал	2,688,700.0	2,720,200.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	341,477,080.8	528,465,750.0
35410	Бичиг хэргийн материал	14,172,300.0	7,057,500.0
35420	Аж ахуйн материал	4,841,400.0	8,622,900.0
35450	Барилгын засварын материал	4,634,540.2	5,202,540.2
35460	Хүнсний материал	595,163.8	611,550.0
35470	Бусад хангамжийн материал	317,233,676.8	506,971,259.8
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>10,378,158,079.7</u></b>	<b><u>10,366,247,576.7</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	10,378,158,079.7	10,366,247,576.7
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	9,491,930,412.8	9,408,482,576.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,658,980,767.0	9,508,961,367.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-756,579,889.1	-884,110,448.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	800,327,766.1	1,118,115,263.1
39206	Хуримтлагдсан элэгдэл	-411,283,099.7	-564,265,108.8
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	400,170,106.6	459,681,306.6
39208	Хуримтлагдсан элэгдэл	-238,845,846.2	-269,060,410.6
39217	Ном	39,160,608.2	39,160,608.2
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	886,227,666.9	957,765,000.1
39301	Програм хангамж	13,715,000.0	13,715,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,782,333.1	-10,574,999.9
39303	Бусад биет бус хөрөнгө	881,295,000.0	954,625,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>10,998,684,607.4</u></b>	<b><u>11,254,864,774.8</u></b>

<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>365,750.0</b>	<b>63,747,748.0</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	365,750.0	63,747,748.0
<b>413</b>	<b>Өглөг</b>	365,750.0	63,747,748.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	365,750.0	00.0
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.0	63,747,748.0
41361	Байгууллагад төлөх өглөг	00.0	63,747,748.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,998,318,857.4</b>	<b>11,191,117,026.8</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	10,998,318,857.4	11,191,117,026.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,483,997,027.7	2,483,997,027.7
51101	Өмч: - төрийн	2,483,997,027.7	2,483,997,027.7
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	7,360,848,618.1	7,703,666,187.6
51210	Өмнөх үеийн үр дүн	7,360,848,618.1	7,510,868,018.1
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	192,798,169.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,153,473,211.6	1,003,453,811.6
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>10,998,684,607.4</b>	<b>11,254,864,774.8</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,608,935,665.8</b>	<b>8,562,232,780.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>208,335,465.8</b>	<b>1,336,558,280.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	208,335,465.8	1,336,558,280.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	147,920,000.0	138,265,400.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	143,500,000.0	128,738,500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,420,000.0	9,526,900.0
120009	Бусад орлого	00.0	954,625,000.0
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	12,695,000.00	194,903,497.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	47,720,465.76	48,764,383.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,400,600,200.0</b>	<b>7,225,674,500.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,541,004,200.0	6,264,200,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,541,004,200.0	6,264,200,800.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	859,596,000.0	961,473,700.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	859,596,000.0	961,473,700.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,475,548,238.2</b>	<b>7,426,881,689.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,475,548,238.2</b>	<b>7,426,881,689.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	6,178,540,983.8	7,188,203,536.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,182,222,372.6	4,873,139,303.7

**Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номун далай цогцолбор сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210101	Үндсэн цалин	2,326,409,890.3	2,978,566,711.7
210102	Нэмэгдэл	1,697,029,632.9	1,643,263,705.0
210104	Урамшуулал	158,782,849.4	251,308,887.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	518,357,900.0	615,125,000.0
210201	Тэтгэврийн даатгал	352,122,400.0	418,285,000.0
210202	Тэтгэмжийн даатгал	41,558,800.0	49,210,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,246,800.0	24,605,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	8,311,900.0	24,605,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	83,118,000.0	98,420,000.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	838,930,695.9	922,161,499.3
210301	Гэрэл, цахилгаан	52,721,689.9	50,711,446.3
210302	Түлш, халаалт	697,217,618.0	782,622,960.0
210303	Цэвэр, бохир ус	88,991,388.0	88,827,093.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	97,164,874.0	139,381,010.1
210401	Бичиг хэрэг	56,309,600.0	93,689,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,242.0	123,043.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,816,032.0	45,568,967.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	58,095,850.0	58,500.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.0	58,500.0
210502	Хоол, хүнс	58,095,850.0	00.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,593,130.0	59,167,700.0
210604	Урсгал засвар	34,593,130.0	59,167,700.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.0	524,200.0
210702	Дотоод албан томилолт	00.0	524,200.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,175,214.0	60,372,528.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.0	00.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,500.0	00.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,164,714.0	60,372,528.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	428,000,947.2	518,273,794.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,155,109.4	115,642,516.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.0	1,350,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	356,845,837.8	401,281,278.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	297,007,254.5	238,678,152.7
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	297,007,224.2	238,678,152.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	234,872,924.2	238,678,152.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,134,300.0	00.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	30.3	00.7
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30.3	00.7
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>133,387,427.5</b>	<b>1,135,351,090.9</b>

225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	272,999.8	942,552,921.4
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	272,999.8	942,552,921.4
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-272,999.8	-942,552,921.4
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>133,114,427.7</u></b>	<b><u>192,798,169.5</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>6,548,520,200.0</u></b>	<b><u>7,363,939,900.0</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>147,920,000.0</b>	<b>138,265,400.0</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	147,920,000.0	138,265,400.0
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	147,920,000.0	138,265,400.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	143,500,000.0	128,738,500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,420,000.0	9,526,900.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,400,600,200.0</b>	<b>7,225,674,500.0</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,541,004,200.0	6,264,200,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,541,004,200.0	6,264,200,800.0
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	859,596,000.0	961,473,700.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	859,596,000.0	961,473,700.0
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>6,155,621,079.1</u></b>	<b><u>7,164,749,917.8</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,155,621,079.1</b>	<b>7,164,749,917.8</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,865,455,892.9</b>	<b>6,926,055,378.9</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,182,925,844.9	4,875,138,524.7
210101	Үндсэн цалин	2,326,409,890.3	2,980,565,932.7
210102	Нэмэгдэл	1,697,029,632.9	1,643,263,705.0
210104	Урамшуулал	159,486,321.7	251,308,887.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	518,357,900.0	615,125,000.0
210201	Тэтгэврийн даатгал	352,122,400.0	418,285,000.0
210202	Тэтгэмжийн даатгал	41,558,800.0	49,210,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,246,800.0	24,605,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	8,311,900.0	24,605,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	83,118,000.0	98,420,000.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	836,595,999.7	920,111,499.3
210301	Гэрэл, цахилгаан	52,554,884.7	50,782,154.3
210302	Түлш, халаалт	695,138,507.0	780,572,960.0
210303	Цэвэр, бохир ус	88,902,608.0	88,756,385.0

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	66,893,287.0	-
210502	Хоол, хүнс	66,893,287.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22,999,970.0	41,362,200.0
210604	Урсгал засвар	22,999,970.0	41,362,200.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	23,583,038.8	139,244,528.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,583,038.8	139,244,528.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	214,099,852.4	335,073,626.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	145,139,652.4	272,034,826.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,960,200.0	63,038,800.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>290,165,186.3</b>	<b>238,694,538.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	290,165,156.0	238,694,538.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	228,030,856.0	238,694,538.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,134,300.0	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	30.3	0.7
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30.3	0.7
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>392,899,120.9</u></b>	<b><u>199,189,982.3</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>155,832,200.0</b>	<b>118,647,452.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>155,832,200.0</b>	<b>118,647,452.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	155,832,200.0	118,647,452.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	155,832,200.0	118,647,452.0
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(155,832,200.0)</u></b>	<b><u>(118,647,452.0)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	237,066,920.9	80,542,530.3
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	38,185,578.0	275,252,498.9
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	275,252,498.9	355,795,029.2

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.7	1,600,184,711.6	7,000,826,639.5	11,085,008,378.8

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	392,167,300.0	392,167,300.0
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.7</b>	<b>1,600,184,711.6</b>	<b>7,392,993,939.5</b>	<b>11,477,175,678.8</b>
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	382,745,375.6	382,745,375.6
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.7</b>	<b>1,153,473,211.6</b>	<b>7,360,848,618.1</b>	<b>10,998,318,857.4</b>
D01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.7</b>	<b>1,153,473,211.6</b>	<b>7,360,848,618.1</b>	<b>10,998,318,857.4</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	150,019,400.0	150,019,400.0
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.7</b>	<b>1,153,473,211.6</b>	<b>7,510,868,018.1</b>	<b>11,148,338,257.4</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.0	-150,019,400.0	00.0	-150,019,400.0
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	192,798,169.5	192,798,169.5
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.7</b>	<b>1,003,453,811.6</b>	<b>7,703,666,187.6</b>	<b>11,191,117,026.8</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	7,576,880,500.0	7,283,397,369.8	293,483,130.3	96.1
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	7,576,880,500.0	7,283,397,369.8	293,483,130.3	96.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,319,537,400.0	7,044,702,830.9	274,834,569.1	96.2
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	5,111,408,300.0	4,875,138,524.7	236,269,775.3	95.4

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номун далай цогцолбор сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	3,551,072,300.0	2,980,565,932.7	570,506,367.3	83.9
210102	Нэмэгдэл	1,396,361,100.0	1,643,263,705.0	(246,902,605.0)	117.7
210104	Урамшуулал	163,974,900.0	251,308,887.0	(87,333,987.0)	153.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	638,926,000.0	615,125,000.0	23,801,000.0	96.3
210201	Тэтгэврийн даатгал	434,469,700.0	418,285,000.0	16,184,700.0	96.3
210202	Тэтгэмжийн даатгал	51,114,100.0	49,210,000.0	1,904,100.0	96.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,557,000.0	24,605,000.0	952,000.0	96.3
210204	Ажилгүйдлийн даатгал	25,557,000.0	24,605,000.0	952,000.0	96.3
210205	Эрүүл мэндийн даатгал	102,228,200.0	98,420,000.0	3,808,200.0	96.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	920,111,500.0	920,111,499.3	0.7	100
210301	Гэрэл, цахилгаан	48,537,800.0	50,782,154.3	(2,244,354.3)	104.6
210302	Түлш, халаалт	782,573,700.0	780,572,960.0	2,000,740.0	99.7
210303	Цэвэр, бохир ус	89,000,000.0	88,756,385.0	243,615.0	99.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	41,362,200.0	41,362,200.0	-	100
210604	Урсгал засвар	41,362,200.0	41,362,200.0	-	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	141,677,600.0	139,244,528.7	2,433,071.3	98.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	141,677,600.0	139,244,528.7	2,433,071.3	98.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	466,051,800.0	453,721,078.1	12,330,721.9	97.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	403,013,000.0	390,682,278.1	12,330,721.9	96.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,038,800.0	63,038,800.0	-	100
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	257,343,100.0	238,694,538.2	18,648,561.8	92.8
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	257,343,100.0	238,694,538.2	18,648,561.8	92.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	257,343,100.0	238,694,538.2	18,648,561.8	92.8
<b>1310</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	7,576,880,500.0	7,363,939,900.0	(1,232,680.0)	100
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	6,264,200,820.0	6,264,200,800.0	20.0	100

131001	Улсын төсвөөс санхүүжих	6,264,200,820.0	6,264,200,800.0	20.0	100
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	961,473,700.0	961,473,700.0	-	100
132001	Орон нутгийн төсвөөс	961,473,700.0	961,473,700.0	-	100
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	137,032,700.0	138,265,400.0	(1,232,700.0)	100.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,000,000.0	128,738,500.0	(33,738,500.0)	135.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,200,000.0	9,526,900.0	23,673,100.0	28.7
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	8,832,700.0	-	8,832,700.0	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	275,252,498.9	(275,252,498.9)	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	275,252,498.9	(275,252,498.9)	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	170	170	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	124	124	-	100
620003	Үйлчлэх ажилтан	45	45	-	100
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	3,160	3,160	-	100
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	3,160	3,160	-	100
630001	Төрийн өмчит ЕБС	3,160	3,160	-	100

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Бид сурлагын чанараараа манлайлан, хамтын ажиллагааг эрхэмлэсэн, зөвд уриалан дуудсан соёлч сургууль байна” гэсэн зорилтын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, биелэлт 98.4 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу сургуулийн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар сургуулийн зөвлөл, Захирлын дэргэдэх зөвлөл, Сургалтын алба, Хүүхэд хөгжлийн албан, Захиргаа аж ахуй гэсэн бүтэц зохион байгуулалттай 164 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд бага ангийн бүлгийн тоо 24, дунд ангийн бүлгийн тоо 34, ахлах ангийн бүлгийн тоо 23 нийт 81 бүлэгтэйгээр 3173 сурагчдыг хичээл сургалтын үйл ажиллагаанд хамруулсан бөгөөд өдрөөр суралцагч 3152 хүүхэд үүнээс бага ангид 986, эмэгтэй 517 эрэгтэй 469, дунд ангид 1304, эмэгтэй 683 эрэгтэй 621, ахлах ангид 862, эмэгтэй 482 эрэгтэй 380 хүүхэд, насан туршийн боловсролын нэгжийн холимог бүлэгт 21 суралцагч суралцан ерөнхий боловсролын мэдлэгийг олгож байна.

Тус сургуулийн нэг онцлох үйл явдал нь тайланд онд түүхт 100 жилийн ойн арга хэмжээг өргөн тэмдэглэн өнгөрүүлсэн байна. Ой арга хэмжээнд 2000 орчим зочид төлөөлөгчид, төгсөгчид оролцсон ба ой үйл ажиллагааны хаалтын арга хэмжээ болон нийт төгсөгчдөд зориулан аймгийн баганат талбайд Соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулсан нь бусад сургуулийн ой арга хэмжээнээс онцлох үйл явдал болсон байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тус сургуульд үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2023 он, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт шалгалт хийгдсэн байна. Хяналт шалгалтаар 546.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 49,669.8 мянган төгрөгийн албан шаардлага, 3,150.0 мянган төгрөгийн зөвлөмж тус тус өгсөн байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Аймгийн Санхүү төрийн санхүү төрийн сангийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/149 дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 256,180.2 мянган төгрөг буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	620,526.5	11.6	888,617.2	7.9	268,090.7	104.6
МӨНГӨН ХӨРӨНГӨ	275,252.5	1.8	355,795.0	40.0	80,542.5	(3.7)
АВЛАГА	1,105.5	2.1	1,636.2	0.2	530.7	(4.2)
УРЬДЧИЛГАА	2.7		-		(2.7)	
БАРАА МАТЕРИАЛ	344,165.8	96.1	531,185.9	59.8	187020.1	107.9
НӨӨЦИЙН БАРАА	-		-		-	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,378,158.1	88.4	10,366,247.6	92.1	(11,910.5)	(4.6)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,378,158.1	88.4	10,366,247.6	92.1	(11,910.5)	(4.6)
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(1,415,491.1)	(18.3)	(1,728,010.9)	(15.4)	(312,519.8)	(96.3)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,998,684.6</b>	<b>100.0</b>	<b>11,254,864.8</b>	<b>100.0</b>	<b>256,180.2</b>	<b>100.0</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	365.7	0.1	63,747.7	0.6	63,382.0	
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,998,318.8	99.9	11,191,117.0	99.4	192,798.2	100.0
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,998,684.6</b>	<b>100.0</b>	<b>11,254,864.8</b>	<b>100.0</b>	<b>256,180.2</b>	<b>100.0</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 355,795.0 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлээр санхүүжсэнтэй холбоотойгоор үндсэн цалин хэмнэгдэж 268,090.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын дансны эхний үлдэгдэл 1,105.5 мянган төгрөг нь 2021 онд үүссэн авлагыг барагдуулсан. Харин эцсийн үлдэгдэл 1,636.2 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн ажил мэргэжлийн кодоос шалтгаалж үүссэн байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2.7 мянган төгрөгийг тооцоо хийж хаасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 531,185.9 мянган төгрөг болж өмнөх оноос 187,020.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн хөрөнгөөр хүүхдийн үдийн хоол хөтөлбөрт 260,653.7 мянган төгрөгийн цахимаар тендерийг 4 багцын хүрээнд нээлттэй сонгон шалгаруулалтаар зарлаж 1 дүгээр багцыг Гэгээн их ХХК, 2, 3, 4 дүгээр багцыг Сүндэрконсракт ХХК -ийг тус тус шалгаруулж 238,694.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Харин эм боох материалд 90.0 мянган төгрөг, бичиг хэргийн материалд 90,784.2 мянган төгрөг, аж ахуйн материалд 25,278.0 мянган төгрөг, барилга засварын материалд 40,235.7 мянган төгрөг, 162,912.6 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ тендер зарлаагүй байна. Мөн бусад хангамжийн материалд хандив тусламжаар 48,764.4 мянган төгрөгийн орлого авсан байна. Тайланд хугацаанд эм боох материалд 58.5 мянган төгрөг, бичиг хэргийн материалд 97,899.0 мянган төгрөг, аж ахуйн материалд 21,496.5 мянган төгрөг, барилга засварын материалд 39,667.7 мянган төгрөг, хүүхдийн үдийн цайнд 238,678.1 мянган төгрөг, бусад хангамж материалд 21,939.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,366,247.6 мянган төгрөг болж 11,910.5 мянган төгрөгөөр буурсан байна. Төсвийн худалдан авалтаар 16 нэр төрлийн 80 ширхэг 148,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 9 нэр төрлийн 172 ширхэг 33,595.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 10 нэр төрлийн 80 ширхэг 153,177.5 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмж, сургуулийн 100 жилийн ойн хүрээнд хандив тусламжаар 7 нэр төрлийн 7 ширхэг 15,060.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 9 нэр төрлийн 88 ширхэг 25,916.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 27 -ний өдрийн 81 дугаар захирамжаар 750.0 мянган төгрөгийн 50 инч телевизор, Аймгийн Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 7 -ний өдрийн А/386 дугаар захирамжийн дагуу тус сургуулийн эзэмшил 3 байршлын 38.185 м.кв газрын нэгжийн үнэлгээг дахин хийж 954,625.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгасан байна. Мөн аймгийн Засаг даргын захирамжийн дагуу сургуулийн эзэмшил 3 байршлын 881,295.0 мянган төгрөгийн газар, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18 -ний өдрийн 98 дугаар захирамжаар 150,019.4 мянган төгрөгийн сурагчдын 2 дугаар байрыг балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,191,117.0 мянган төгрөг болж 192,798.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 192,798.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,645,239.4 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 243,748.5 мянган төгрөгөөр

бууруулж 5,401,490.9 мянган төгрөгөөр баталсан байна. Мөн орон нутгийн төсөвт тогтмол зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 983,808.0 мянган төгрөгөөр тооцон хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 32,334.3 мянган төгрөгөөр бууруулж 951,473.7 мянган төгрөг баталсан байна.

Тайлант хугацаанд Боловсролын ерөнхий газрын даргын 12 удаагийн тушаалаар улсын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж 6,615,406.8 мянган төгрөг, Баянхонгор сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн А/271 дугаар захирамжаар урсгал засварын зардалд 10,000.0 мянган төгрөгийг нэмж олгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 6,264,200.8 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтээр 961,473.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл болон үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 351,206.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 7,283,397.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,283,397.7 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь цалин болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн 260,070.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 12,330.7 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 18,648.6 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна. 71802 ерөнхий боловсрол хөтөлбөрийн хүрээнд 13 арга хэмжээнд зарцуулж 293,483.1 мянган төгрөг хэмнэгдсэн нь харилцах дансанд үлдэгдлээр байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	15,648.9	15,648.9	-	100
2	80233 Хүүхэд хамгаалал	14,968.4	14,968.4	-	100
3	80312 Сургалт семинар	10,429.3	10,374.8	54.5	99.5
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	15,655.4	15,655.4	-	100
5	81801 Үдийн цай хөтөлбөр	257,343.1	238,694.5	18,648.6	92.7
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	131,942.1	131,942.1	-	100
7	81823 Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	46,931.8	44,127.9	2,803.9	94
8	81827 Бичиг үсгийн боловсрол	29,059.9	29,059.9	-	100
9	81834 Боловсролын стандарт, сургалт	5,745,217.7	5,494,375.5	250,842.2	95.6
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	178,623.1	168,083.0	10,540.1	94.1
11	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	137,032.7	128,871.9	8,160.8	94
12	81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	32,554.4	30,121.3	2,433.1	92.5
13	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	961,473.7	961,473.7	-	100
14	Дүн	7,576,880.5	7,283,392.4	293,483.1	96.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тус сургууль нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 782,573.7 мянга, гэрэл цахилгааны зардалд 48,537.8 мянга, цэвэр бохир усны зардалд 89,000.0 мянган төгрөг батлагдсанаас Баялаг дулаан ХХК дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК, цахилгаанаар хангах гэрээ, Чандмань Баянхонгор ХК цэвэр бохир усны гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр хүүхдийн үдийн хоол хөтөлбөрт нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж тендерт шалгарсан Гэгээн их ХХК багц 1 Мах махан бүтээгдэхүүн 117,704.2 мянган төгрөг, Сүндэрконсракшнг ХХК багц 2 Гурил, үр тариа, бусад хүнсний бүтээгдэхүүн, багц 3 Сүү, сүүн бүтээгдэхүүн, багц 4 Хүнсний ногоо, жимс жимсгэнэ 85,079.8 мянган төгрөг, Софтвишн ХХК 35,910.5 мянган төгрөг нь өмнөх оны гэрээ нь 2024 оны худалдан авах ажиллагаа зохион байгуулах хүртэл үргэлжилсэн байна.

Тендерийн ерөнхий гэрээний хүрээнд Мексим консалтинг ххк 84,997.0 мянган төгрөг, Монголын цахилгаан холбоо ХК 51,279.0 мянган төгрөг, Ай и ди си ХХК 17,145.9 мянган төгрөг, Техно зон ХХК 26,970.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна

2024 оны төсөв Хадат бодь ХХК 41,676.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, Алтайн гурван нуур ХХК 29,054.2 мянган төгрөгийн засварын материал, иргэн Амартунгалаг 10,601.0 мянган төгрөгийн засварын материал, Баян баялаг өргөө ХХК 6,335.7 мянган төгрөгийн аж ахуйн материал, Би Ай Эм Би ХХК 27,171.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, Дижитал Эдү менежмент ХХК 42,980.0 мянган төгрөгийн цахим хичээлийн төлбөрийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах талаар дараагийн аудитын анхаарах асуудалд бичсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Номун далай сургууль нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 03 -ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн захирал Ц.Алтангэрэл нь 2024 оны 12 дугаар сарын 24 -нийг хүртэл, захирал Ц.Буянтогтох нь 2024 оны 12 дугаар сарын 24 -өөс хойш, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч П.Амаржргал нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 7,576,880.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 75,768.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 49,249.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5.4 заасны дагуу цалин болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн 260,070.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 12,330.7 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 18,648.6 мянган төгрөг зарцуулаагүй нийт 293,483.1 мянган төгрөг хэмнэгдсэн харилцах дансанд

үлдэгдлээр байна. Харин орон нутгийн төсвийн санхүүжилтээс 0.6 мянган төгрөг хэмнэгдэж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан орлогын 7,225,117.7 мянган төгрөгийн 68 мэдээлэл, зарлагын 1,390,576.9 мянган төгрөгийн 72 мэдээлэл, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” заасан 861,657.9 мянган төгрөгийн 49 шийдвэрийг хуулийн хугацаанд нь мэдээлсэн байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймгийн Номгон аудит ХХК -ийн ахлах аудитор О.Мандах гүйцэтгэж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар хяналтыг хэрэгжүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд бараа үйлчилгээний бусад зардлыг бичиг хэргийн материал, бусад хангамжийн материал, барилга засварын материал тус бүрд нь худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 17,199.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 655.4 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 16,544.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгөв.

#### **5.1 Төлбөрийн акт**

5.1.1 Албан хаагчдыг сургуулийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 08 -ний өдрийн А/30 дугаар тушаалаар Хужирт рашаан сувилалд амруулахдаа 655.4 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төсөв хэтрүүлэн зарцуулсан 655.4 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

5.2.1 Аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын 2024 оны 7 дугаар сарын 5 -ний өдрийн 267 дугаар албан бичгээр тус сургуулийн захирал Ц.Алтангэрэл нь 1 сарын үндсэн цалин 1,544.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч байна.

5.2.2 Сургуулийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 08 -ний өдрийн А/30 дугаар тушаалаар албан хаагчдыг эрүүл мэндийг үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулах үүднээс Хужирт рашаан сувилалд 15,000.0 мянган төгрөгийг зарцуулж уламжлал эмчилгээ хийлгэсэн байна.

Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 6 дугаар сарын 29 -ний өдрийн А/238, А/340 дугаар “Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 6 дугаар сарын 29 -ний өдрийн А/238, А/340 дугаар тушаалын дагуу багш нарыг нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд хамруулж байх албан шаардлага өгч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөв хэтрүүлэн зарцуулсан 655.4 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.	1	655.4	1	655.4				